**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 02 өдөр　　　　Дугаар А/427　　　　Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42 дугаар зүйлийн 42.2.1 “а” заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах ажиллагааны зардлын санхүүжилтийн эх үүсвэрт “Хөшөөт хөгжил сан”-аас 40.0 сая төгрөгийг зохицуулан зарцуулсугай.

2.Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах ажиллагааны санхүүжилт 40.0 сая төгрөг /дөчин сая/-ийг “Хөшөөт хөгжил сан”-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний урьд оны үлдэгдлээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Тус санхүүжилтийг үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажиллагааны зардалд тусган батлуулж зарцуулан, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА　　　　Б.ДҮГЭРЖАВ

Zax A/427 Ch
02 02128